



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар A/149

Улаанбаатар хот

Ажлын тусгай хувцас олголт болон
ашиглалтын журам, техникийн тодорхойлолт
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.2, 20.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, “Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 6.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжийн төвийн ажлтнуудад ажлын хувцас олголт ба ашиглалтын журмыг нэгдүгээр, ажлын тусгай хувцасны техникийн тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн /М.Энэбиш/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Б.Батсайхан/-т даалгасугай.



Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2021 оны 11 дүгээр сарын 11... -ний
өдрийн *А/Ч* дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

АТДЛСТВ 5645913
9021010604

АЖЛЫН ХУВЦАСНЫ ОЛГОЛТ БА
АШИГЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журмын зорилго нь “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын нийт албан хаагч, ажилтнуудын өвөл, зуны ажлын хувцас болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, бүртгэх, хянах үйл ажиллагааны харилцааг зохицуулна.

1.2. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т ажиллаж буй нийт албан хаагч, ажилтнуудад нэг бүрийн хамгаалах хэрэгслийг, заавар болон зориулалтын дагуу “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСНЫ ДАРАА АЖЛАА ЭХЭЛҮЕ” уриан дор, тогтмол, зөв хэрэглэж хэвшүүлэх зорилготой.

Хоёр. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

2.1. Энэхүү журмыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын бүх албан хаагч, ажилтнууд дагаж мөрднө.

2.2. Энэхүү журмыг хэлтсийн дарга нар ажилтнууддаа танилцуулах үүрэг хүлээнэ.

Гурав. ТОДОРХОЙЛОЛТ, НЭР ТОМЬЁО

3.1.“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын нийт албан хаагч, ажилтнуудын ажлын хувцас нь батлагдсан өнгө загвар, иж бүрдэл бүхий стандартын шаардлага хангасан байна.

3.2.“Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нэлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зориулалт бүхий стандартад нийцсэн доорх хэрэгслүүдийг хэлнэ.

3.2.1 Хамгаалалтын болон гэрэл ойлгогч бүхий хувцас

3.2.2 Толгой хамгаалах хэрэгсэл

3.2.3 Нүд хамгаалах хэрэгсэл

3.2.4 Хөл хамгаалах хэрэгсэл

3.2.5 Гар хамгаалах хэрэгсэл

3.2.6 Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл

3.2.7 Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл

3.2.8 Уналтаас хамгаалах аюулгүйн бус багтана.

3.3 Осол: Үйлдвэрлэл түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцож байх явцдаа эрхтэн нь гэмтэх, эрүүл мэнд хохирох

3.4 Аюул: Механик, хими, хөлдөх, өндөр температурын буюу галын, био нэгдэл, цацрагийн зэрэг аюулын үйлчлэлээс бий болсон ослын бодит эх үүсвэр

3.5 Эрсдэл: Осол учруулах магадлалтай тохиолдлуудын нийлбэр буюу тухайн ослын зэрэглэл

3.6 Ажлын тусгай хувцас: Гадны нэг болон хэд хэдэн тааламжгүй нэлөөллөөс хамгаалах зориулалтаар хийсэн хувцас

3.7 Ажлын хувцасны иж бүрдэл нь доорх хэсгээс бүрдэнэ.

- Өвөл: Куртик, өмд, гутал

- Зун: Цамц, хантааз, өмд, гутал

3.8 Хамгаалах хэрэгсэл: Хүмүүсийг цахилгааны үйлчлэл, өндөр ослын унах, галд өртөх, дулаан ба механик үйлчлэлд нэрвэгдэхээс болон гэмтэхээс хамгаалахад зориулсан хүний

аюулгүй байдлыг бүрэн хангаж чадах тусгаарлагч материалаар хийсэн хөдөлмөрийн багаж хэрэгслийд

Дөрөв. АЖЛЫН ХУВЦСЫГ ХЭРЭГЛЭХ ОРЧИН

4.1. Ажлын талбайд: Лабораторийн туршилтын өрөө, Хот болон хөдөө орон нутгийн зам дээр туршилт, шинжилгээ хийх, хяналт тавих, Техник ашиглалтын түвшин тогтоох ажлын талбай дээр, Хөшигийн хөндийн хурдны авто зам дээр, Төлбөр авах цэгийн байрууд

4.2. Ажлын байранд: Төвийн 2 байр, хоолны өрөө, амралтын байр, спорт зал, авто машины граж, хамгаалалтын байр, ариунцэврийн өрөөнүүд

Тав. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд зохицсон эсэхийг ажилтан болон шууд удирдлага доорх шаардлагуудын дагуу магадлана.

5.1.1. Ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь тухайн ажилтанд саад болохгүй байх

5.1.2. Ажилтныг шаардагдах түвшинд хамгаалахаас гадна, хүний биед тохиромжтой байх

5.1.3. Ажлын хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц ирмэггүй байх

5.1.4. Хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц эсвэл хэмжээний өргөн сонголттой байх

5.1.5. Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйлүүдийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх

5.1.6. Хувцасны хамгаалалтын түвшин өндөр, бөх бат хийгдсэн, хөнгөн эдийн засгийн хувьд үр ашигтай байх

5.1.7. Ажлын тусгай хувцас нь боломжтой хэмжээгээр, ус уур нэвтрүүлэхгүй байх, биед нөлөөлөх бусад хүчин зүйлийг бага болгох буюу байхгүй байлгах хэрэгтэй.

5.1.8. Хамгаалах хэрэгслийд нь MNS 4931 2000, 5388 2004, 5389 2004, 5620 2006, 5621 2006, 5622 2006, 5624 2006 стандартуудыг хангасан байх

5.1.9. Хамгаалах хэрэгсэл бүр баталсан норматив техникийн баримт бичигтэй, бүрэн хамгаалах чадвартай, гоо зүйн болон эргономикийн шаардлага хангасан байх

5.1.10. Тусгай хамгаалах хэрэгсэл нь ашиглалт, эрүүл ахуй, физиологи, хамгаалалтын үнэлгээг үнэлсэн үзүүлэлт, ашиглалтын заавартай байх

5.2. Ажилтан өөрийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

5.3 Ажлын талбарт ямар нэгэн ажил гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны дүрмээр заавал биелүүлэх, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээгээр заагдсан нэг бүрийн хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.

5.4. Ээлжийн амралт, хуваарьт амралт, ажлын бус цагаар нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ажлын хувцас хэрэглэхийг хориглоно.

5.5. Ажилтан амралтаа дуусган ирэх үед нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсыг ахлагч нь дахин шалгана.

5.6. Зочид, ажил шалгах, танилцах зорилгоор талбай дээр ажиллах хүмүүсийг дараах хамгаалах хэрэгслээр түр хангана.

5.6.1 Гэрэл ойлгогч түүз бүхий хантааз

5.6.2 Дуулга

5.6.3 Хамгаалалтын шил

Зургаа. ХӨДӨЛМӨРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ,
АЖЛЫН ХУВЦАСНЫ АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

6.1. Ажлын хувцасны өнгө загвар иж бүрдлийг Төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нар хариуцна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АВТО ЗАМЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨВ ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНУУДАД ОЛГОХ АЖЛЫН ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЭЛ, ЧЭВЭРЛЭГЭНИЙ МАТЕРИАЛЫН НЭР ТӨРӨЛ ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЧАНЫ НОРМАТИВ

6.2. Ажилтнуудын зуны хувцасыг олгохдоо тухайн жилийн 3 сард, өвлийн хувцасыг олгохдоо тухайн жилийн 10 сард, ИТА-нуудад зун болон өвлийн хувцсыг 3 жил тутамд 1 удаа олгох /Үүнд: Лабораторийн ажилтнуудад өвөл зуны хувцас орсон болно./ ба хангандийн нийлүүлэлтийг Төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, Төлбөр авах цэгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нар хариуцна.

6.3. Төлбөр авах цэг, Хурдны замын алба, Техник ашиглалтын түвшин тогтоох баг, үйлчилгээний алба зэрэг хэлтэс, алба нэгжүүдэд ажиллаж байгаа ажилтнуудын өвөл зуны ажлын хувцасыг тус бүр 24 сард 1 удаа, лабораторийн ажилтнуудын халад малгай, туслах ажилтнуудын хувцасыг жилд 1 удаа сольж тус тус олгоно.

6.4. Лабораторийн ажилтнуудад олгох ажлын хамгаалах хувцас, хэрэгсэл, цэвэрлэгээний материалын нэр төрөл эдэлгээг хугацааны нормативаар тооцно. /хүснэгт 1/

6.5. Хөдөлмөрийн хамгаалалтын хувцасны ерөнхий шаардлага - MNS, ISO 13688:2000, MNS, ISO 136885:1998 гэсэн стандартуудыг мөрдөнө. Энэ стандартаар ажлын тусгай хувцасны эргономик, ашиглалтын хугацаа, хэмжээ, марк, угаалга цэвэрлэгээнд тавих ерөнхий шаардлагыг тогтоосон.

6.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтнүүд шаардлага хангахгүй болсон ажлын хувцас, нэг бүрийг хамгаалах хэрэгслийн акт үйлдэн устгана.

6.7. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажлын нөхцөл байдал элэгдлээр нь тооцон нэмж олгохын тулд жагсаалт гарган санхүүгээр шалгуулан бүртгүүлээд, няраваар олгуулна.

6.8. Ажилтан нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны ашиглалтын хугацаа, дууссан, цэвэрлэх боломжгүй болох, аюулгүйн шаардлага хангахгүй болох зэрэг шалтгааны улмаас солих шаардлага гарсан бол шууд удирдлагадаа хүсэлт тавина.

6.9. Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нөөцийг тухайн жилийн нийт ажилтнуудын 30 хүртлэх хувиар тооцно.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, мөрдүүлж ажиллах үүргийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтнүүд хариуцах бөгөөд журам зөрчсөн ажилтан болон харьяа хэлтсийн удирдлагад шаардлага тавьж зөрчлийг арилгах хэрэгтэй.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн ажилтны санаатай болон болгоомжгүй, хайхрамжгүй байдал, гэм буруутай үйлдлийн улмаас нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг алга болгох, гэмтээх, хэрэглэх боломжгүй болсон тохиолдолд Захиргаа, санхүүгийн хэлтэс байгууллагын хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага ногдуулж, учирсан хохирлыг барагдуулна.

7.3. Ажилтан ажлаас халагдах, өөр ажилд шилжсэн тохиолдолд ажилласан сараар хувцасны элэгдэл хорогдлыг суутгахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс хариуцна..

7.4. Шууд удирдлага нь ажилтны ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн ашиглалтанд хяналт тавих, бүртгэх ба ажлын хувцас хэрэглэлийг ажлын байрнаас өөр газарт хэрэглэсэн, сахилгын зөрчил гаргасан тохиолдолд захиргааны арга хэмжээ авах санал гаргах эрхтэй.

НЭГ БУРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ ЗААВАР

Нэг. ТОЛГОЙ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

1.1. Толгой хамгаалах хэрэгсэл /каск/-ыг ажлын талбарт ажиллаж байгаа нөхцөлд болон толгой дээрээс гадны биет унах эрсдэл бүхий газруудад байнга өмсөнө.

1.2. Удирдлага болон ажилтан зочдын толгой хамгаалах хэрэгслийн өнгийг доорх байдлаар ялгана.

1.2.1 Удирдлага, ИТА-Цагаан

1.2.2 Ажилтан - Улбар шар

1.2.3. ХАБЭА, ГАБ – Улаан өнгийн каск өмсөнө.

1.3. Албан өрөө, хоолны газар болон тээврийн хэрэгсэл дотор толгойн хамгаалалт буюу каск өмсөх шаардлагагүй.

1.4. Бүх ажилтнууд өөрсдийн хамгаалалтын каскаа шалгах, цэвэрлэх, засварлах үүрэгтэй.

Хоёр. НҮД ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

2.1. Лабораторийн ажилтнууд туршилт, шинжилгээний үед нүдний шил зүүнэ.

2.2. Гагнуурчин, сантехникч, цахилгаанчин, мужаан нар шаардлагатай үед шил зүүнэ.

2.3. Байгалийн гамшигт үзэгдэл, салхи шуурга, нарнаас хамгаалсан шил зүүнэ.

2.4. Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл эзэмшигч нь хариуцсан аливаа хэрэгслээ хэрхэн арчлах, хадгалах тухай зааврын дагуу, заасан хугацаанд эдлэх үүрэгтэй.

Гурав. ХӨЛ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

3.1. Түр гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудыг шаардлагатай гэж үзвэл хамгаалах хэрэгслээр хангана.

3.2. Хамгаалалтын ажлын гутлаа сайтар үдсэн байх ёстой.

3.3. Ажилтнууд хальтрах аюулаас болгоомжлохын тулд, хамгаалалтын гутлын ул элэгдсэн эсэхийг өөрсдөө шалгаж байх шаардлагатай.

3.4. Хурдны замын арчлалтанд ажиллаж байгаа ажилтнууд урт түрийтэй, шагайн бүтэн хамгаалалттай хувцас өмсөнө.

3.5. Хамгаалалт бүхий гутлыг ажлын талбайгаас бусад газар өмсөх шаардлагагүй боловч, энгийн гутлыг ажлын талбайд өмсөхийг хориглоно.

Дөрөв. ГАР ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

4.1. Лаборатори, Хурдны зам, ТАТТ, үйлчилгээний ажилтнууд гар гэмтэх ажил хийж гүйцэтгэхдээ тухайн ажилд тохирсон гарын хамгаалалт буюу бээлийг заавал өмсөх хэрэгтэй.

4.2. Лаборатори, Хурдны зам, ТАТТ, үйлчилгээний албаны ажилтнуудыг гарын хамгаалалт буюу бээлийгээр хангах бөгөөд шаардлагатай гэж үзвэл түр ажиллахаар ирсэн ажилтнуудад олгоно.

4.3. Гагнуурчин, сантехникч, цахилгаанчин, мужаан нар шаардлагатай үед зориулалтын бээлийг өмсөнө.

4.4.

Химийн хортой бодистой харьцахад зориулалтын резинэн бээлийг өмсөнө.

Тав. ХАМГААЛАЛТЫН БОЛОН ГЭРЭЛ
ОЙЛГОГЧ БҮХИЙ ХУВЦАС

5.1. Хортой болон идэмхий бодисын аюул бүхий орчинд ажиллах тохиолдолд ус нэвтэрдэггүй хамгаалалтын хувцасыг байнга өмсөнө.

5.2. Ажилтнууд өөрсдийнхөө хувцасыг таарч байгаа эсэхийг магадлана. Хэт томдсон хувцасыг ажлын талбайд өмсөхийг хориглоно.

5.3. Ашиглаж байгаа тоног төхөөрөмжтэй орооцолдох аюултай үед урагдсан хувцасыг сольж, унжсан зүйлийг авч хаяна.

5.4. Майк, богино өмд, ханцуйгүй цамцыг ажлын талбайд өмсөхийг хориглоно.

Зургаа. СОНСГОЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

6.1. Дуу чимээ ихтэй газар болон дуу чимээ их гэсэн тэмдэг бүхий газруудад сонсголын хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ.

6.2. Ажилтнууд ажлын талбайд байгаа тохиолдолд чихэвчний радио, хуурцаг тоглуулагч, зөөврийн хөгжим, кино тоглуулагч зэрэг зүйлсийг хэрэглэхгүй ба зөвхөн ажлын зориулалтаар гар утсыг ашиглана.

Долоо. АМЬСГАЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

7.1. Замын шороо тоос, лабораторийн туршилт шинжилгээний тоос, химийн бодис, утаа, угаар болон агаарын найрлага дахь хорт хийн бүтээгдэхүүнээс хамгаалах зорилгоор амьсгал хамгаалах хэрэгсэл болох нэг удаагийн амны хаалт, хошуувчтай амьсгалын баг, тусгай хий соруулсан амьсгалах хэрэгсэл, амьсгалын аппарат зэргийг хэрэглэнэ.

7.2. Агаарт тархсан тоосонцор, утас тортог, хорт утас, хий, уур манан ба ууршилттай орчинд ажиллагсад тухайн нөхцөлд тохирсон зориулалтын амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.

7.3. Ялангуяа сорьц дээжинд шинжилгээ хийх лаборатори, сорьцонд шатаах, ууршуулах шинжилгээ хийх бол ажиллагсад нүүрийг бүрэн битүүмжлэн хаасан зориулалтын маск зүүх ёстой ба зориулалтын маск зүүгээгүй ажиллагсдыг дээрх газруудад ажиллахыг хатуу хориглоно.

7.4. Амьсгалын замын хамгаалах хэрэгслийг хэрэглэж буй ажилтан нь олон удаагийн хэрэглэх хэрэгслийг өөрсдөө цэвэрлэж арчилж, цэвэр тоосгүй орчинд хадгалах үүрэгтэй.

7.5. Амьсгал хамгаалах хэрэгслийн шүүлтүүрийг тухайн агаарын бохирдолд тохируулан хэрэглэнэ.

Найм. УНАЛТААС ХАМГААЛАХ БҮС

8.1. Шаардлагатай үед ажилтнуудыг уналтаас хамгаалах хэрэгслээр хангаж ажиллана.

8.2. Уналтаас хамгаалах хэрэгслийг доорх нөхцөлд ажиллаж буй ажиллагсад заавал хэрэглэх шаардлагатай.

8.2.1. Нэг метрээс дээш байнгын суурилуулсан өндөрт ажиллагсад, 3 метрээс дээш түр суурилуулсан өндөрт ажиллагсад хашлага хаалт, бариул байхгүй нөхцөлд ажиллах

8.2.2. Ажиллагсад битүү сав, бункер, амьсгаа боогдож бахардаж болзошгүй орчинд ажиллах

8.2.3. Ажилтнууд ямар нэгэн химийн бодис, янз бүрийн материалтай сав болон ажиллаж байгаа машин техник рүү унаж болзошгүй нөхцөлд ажиллах

8.3. Ажилтнууд унахаас хамгаалах хэрэгслийг хэрэглэхийн өмнө өөрсдөө биечлэн хамгаалалтын хэрэгсэлд ямарваа нэг эвдрэл гэмтэл байгаа эсэхийг сайтар шалгах үүрэгтэй.

8.4. Эвдрэл гэмтэлтэй хамгаалалтын хэрэгсэл хэрэглэхийг хатуу хориглоно.

8.5. Унахаас хамгаалах бүх хэрэгслийг хэрэглээгүй үедээ зориулалтын хадгалдаг газар нь буцааж өгч зөв хурааж хадгална.

Ес. ХӨДӨЛМӨРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН СТАНДАРТ

9.1. **MNS 4931 2000:** Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл - Ерөнхий шаардлага, ангилал, Энэ стандарт нь ажилтнуудын үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлээс ажилчдыг хамгаалах буюу түүний нөлөөллийг бууруулах зориулалтаар хэрэглэх хэрэгслүүдэд хамаарч, ажилтнуудын хамгаалах хэрэгслийн ерөнхий шаардлага, ангиллыг тогтооно

9.2. **MNS 5388 2004:** Толгой хамгаалах хэрэгсэл - сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө. чихэвч) - техникийн ерөнхий шаардлага, Эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээ (шуугианы хүч 85дб)-ээс дээш шуугиан бүхий аж ахуйн нэгж, байгууллагад энэхүү стандартыг мөрдөнө. **4931мМм**

9.3. **MNS 4931: 2000:** Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл- Ерөнхий шаардлага, ангилал

Энэ стандарт нь ажилтнуудын үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлээс ажилчдыг хамгаалах буюу түүний нөлөөллийг бууруулах зориулалтаар хэрэглэх хэрэгслүүдэд хамаарч, ажилчдын хамгаалах хэрэгслийн ерөнхий шаардлага, ангиллыг тогтооно

9.4. **MNS 5389 2004:** Толгой хамгаалах хэрэгсэл - Нүд хамгаалах хэрэгсэл - Нүдний шил Техникийн ерөнхий шаардлага

Энэхүү стандарт нь үйл ажиллагааны явцад гадны биет үсрэх, хурц гэрэл, туяа үүсэх эрсдэл бүхий ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

9.5. **MNS 5620 2006:** Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл. (Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг) Энэ стандартын зорилго нь эрүүл ахуйн зөвшөөрөгдхөх хэмжээнээс их агууламж (тоос, хорт хий, химийн бодис болон бусад) бүхий агаараар амьсгалж

байгаа амьсгалын замын эрхтнийг хамгаалах хэрэгсэл (хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг)-д тавих эрүүл ахуйн шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ Эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс их тоос, хорт хий болон химийн бодисын агууламж бүхий ажлын байрны орчинтой аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

9.6. **MNS 5621 2006:** Толгой хамгаалах хэрэгсэл – Дуулга Энэ стандартын зорилго нь ажлын байранд толгойг механик биет, үйлдвэрийн тааламжгүй нөлөөллөөс хамгаалах дуулганд тавих шаардлагыг тогтооход чиглэнэ Энэхүү стандарт нь гадны болон механик биет толгой дээр унах эрсдэл бүхий ажил үйлчилгээ эрхэлдэг бүх аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна.

9.7. **MNS 5622 2006:** Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага

Энэ стандарт нь ажлын байранд гарыг механик үйлчлэл, химийн бодис, хүйтэн ба халууны үйлчлэл, цахилгаан хүчдэл, доргионос хамгаалах оөмөл, полимер материалан, сүлжмэл бээлийд тавих шаардлагыг тогтооход оршино. Энэхүү стандарт нь үйл ажиллагааны явцад хүний гар мөханик үйлчлэл, химийн бодис, хүйтэн ба халууны үйлчлэл, цахилгаан хүчдэл, доргионос нөлөөлөх эрсдэл бүхий ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна. Энэ стандарт нь бээлийд тавих ерөнхий шаардлагууд, гарын хэмжээ ба хөдөлгөөнд бэлэн бүтээгдэхүүний эвтэй байдлыг тодорхойлох туршилтын аргуудыг багтаасан болно.

9.8. **MNS 5624 2006:** Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч

Энэ стандартын зорилго нь жижиг механик биет, гэрэл, дулаан, химийн бодисоос нүүрийг хамгаалах хэрэгсэл /нүүрэвч/-д тавих шаардлагыг тогтооход оршино. Энэхүү стандарт нь үйлдвэрлэл, үйлчилгээний явцад мөханик биет, гэрэл, дулаан тоос шороо, химийн бодис нүүрэнд нөлөөлж болох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна. стандартуудыг тус тус хангасан байна.



Зам, тээврийн хөгжлийн төвийн захирлын
2021 оны 11 дүгээр сарын 11.. –ний
өдрийн 11/49 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

5645913
АТАД1978 9021010604

АЖЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын тусгай хувцас нийлүүлэх хэлтэс, алба, Төлбөр авах цэгүүд холбогдох удирдлагууд дараах стандартуудтай дүйцэхүйц стандартыг дагаж мөрднө.

Энэхүү стандартыг Зам, Тээврийн хөгжлийн төвийн нийт ажилтнууд, ажлын тусгай хувцас нийлүүлэх үйлдвэр, аж ахуйн нэгж салбарын холбогдох удирдлагууд дагаж мөрднө.

- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага
- ISO 105- Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворталтын сорилт
- ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох
 - ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах
 - ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн –хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгонд кодлох
 - ISO-9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын эзэлхүүн, агаарын хэмжээ
 - ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт
 - MNS ISO 1835 -3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м²-ийн жин тодорхойлох арга
 - MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
 - MNS ISO 1835-5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээний нягт тодорхойлох арга
 - MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт
 - MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга
 - MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
 - MNS ISO 1835 -13:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Үрэлт тэсвэрлэлт тодорхойлох арга
 - MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга
 - MNS ISO 4072 : 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга
 - MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
 - MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга
 - MNS ISO 4073:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга
 - MNS 4010-2009- Ширхэгтийн бүрэлдэхүүн

1. ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Ажлын тусгай хувцас

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.1.1. Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас–ерөнхий шаардлага MNS 13688:2000”

Монгол улсын стандарттай дүйцэхүйц шаардлагыг хангасан байна.

1.1.3. Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байна.

1.1.4. Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байна.

1.1.5. Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх

1.1.6. Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон

байх

1.1.7. Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх

1.1.8. Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх

1.1.9. Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

1.2. Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

1.2.1. Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

1.2.2 Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх

1.2.3 Ус,тос, масло нэвтрүүлэхгүй байх

1.2.4. Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх.

1.2.5. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй.

1.2.6. Хүний биед харшлахгүй байх.

1.2.7. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас,өндөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.

1.2.8. Өндөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх

1.2.9. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.

1.2.10. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх

1.2.11. Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна

1.2.12. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна.

1.2.13. Оруулгын өнгө саарал байна.

2. Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага:

2.1. Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх

2.2. Ус,тос, масло нэвтрүүлэхгүй байх

2.3. Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх.

2.4. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй. Хүний биед харшлахгүй байх.

2.5. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас,өндөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.

2.6. Өндөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх

2.7. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.

2.8. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх

2.9. Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна

2.10. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оруулгын өнгө саарал байна.

3. Ажлын тусгай хувцасны ангилал

Ажлын байр, хөдөлмөрийн нөхцлөөс хамааруулж ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудыг дөрвөн хэсэгт хуваана.

3.1. Ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудын мэргэжлийн ангиллыг албан тушаалын онцлогоос хамаарч 1-р хүснэгтэд заасны дагуу байна.

1-р хүснэгт

Д/д	Мэргэжлийн ангилал	Албан тушаалын нэр			
		Удирдлага	ИТА		Бусад
1	Ажлын тусгай хувцсаар хангах I А хэсэг	Компанийн удирдлага, алба, хэлтсийн дарга	Хэсгийн ахлагч нар, ИТА-нууд.		
2	Ажлын тусгай хувцсаар хангах I Б хэсэг				Оффесийн ажилтнууд
3	Ажлын тусгай хувцсаар хангах II хэсэг	-	ЭША, лабораторийн ИТА	-	
4	Ажлын тусгай хувцсаар хангах III хэсэг	-	-	Лабораторийн туслах ажилчид, Хурдны замын ажилчид, жолооч, жижүүрүүд	-
5	Ажлын тусгай хувцсаар хангах IV А хэсэг				ТАЦ-ийн ажилтнууд
6	Ажлын тусгай хувцсаар хангах IV Б хэсэг				Үйлчилгээний ажилтнууд

4. Ажлын тусгай хувцасны өнгө

4.1. Ажлын тусгай хувцасны өнгийг 2,3-р хүснэгтэд заасны дагуу байх бөгөөд өвөл ба зуны улиралд өмсөх хувцсанд адил хамаарна.

2-р хүснэгт

Мэргэжлийн ангилал	Өвлийн хувцас		
	Хүрэм		Өмд
	Үндсэн	Нэмэлт /оруулга/	
Ажлын тусгай хувцсаар хангах I хэсэг	Цайвар хөх	Саарал	Саарал
Ажлын тусгай хувцсаар хангах II хэсэг	-	-	-
Ажлын тусгай хувцсаар хангах III хэсэг	Тод цэнхэр	Шар	Тод цэнхэр
Ажлын тусгай хувцсаар хангах IV А хэсэг	Тод хөх	Шар	Тод хөх
Ажлын тусгай хувцсаар хангах IV Б хэсэг	Тод хөх	Шар	

3-р хүснэгт

Мэргэжлийн ангилал	Зуны хувцас			
	Хүрэм		Хантааз	Өмд
	Үндсэн	Нэмэлт /оруулга/		
Ажлын тусгай хувцсаар хангах I А хэсэг	Саарал	Хар Саарал		Хар саарал
Ажлын тусгай хувцсаар хангах I Б хэсэг	-		Саарал	-
Ажлын тусгай хувцсаар хангах III хэсэг	Тод цэнхэр	Шар		Тод цэнхэр
Ажлын тусгай хувцсаар хангах IV А хэсэг		Шар	Тод цэнхэр, шар оруулгатай	Тод цэнхэр

4-р хүснэгт

Мэргэжлийн ангилал	Зуны хувцас			
	Халат, малгай		Өмд	
	Үндсэн	Нэмэлт /оруулга/		
Ажлын тусгай хувцсаар хангах II хэсэг	Тод хөх			Тод хөх
Ажлын тусгай хувцсаар хангах IV Б хэсэг	Шар	-		-

5. Ажлын тусгай хувцасны загвар болон зохион бүтээлт

5.1. Ерөнхий шаардлага

5.1.1. Хувцасны загвар ба хэмжээ нь өмсөх хүний ая тухыг боломжтой байдлаар хангах ба хөдөлгөөнд саад болохоргүй байна.

5.1.2. Хувцасны зохион бүтээлт нь түүнийг өмсөх үед биед эвтэйхэн, ажил хөдөлмөр эрхлэхэд саад болохгүй байна.

5.1.3. Гадны нөлөөллөөс хамгаалах чадвар сайтай байна.

5.1.4. Өвлүүн хувцас нь биеийн болон гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах зорилгоор ханцууйн урд хэсгийн оруулгыг энгэрийн хажуугийн босоо оруулгатай босоо нэг бүрдэл хэсэг байхаар хийнэ.

5.1.5. Хөдөлгөөний чөлөөтэй байдлыг хангах оёдол, зохион бүтээлт, зүсэлт нь 1-2-р зурагт үзүүлсний дагуу байна.

5.2 Өвлүүн хувцасны загвар

5.2.1. Хүрэмний загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

А. Товчлоосоор салхи орох, дулаан алдахаас сэргийлэх даралт /планктай/ дарсан

Б Дотор тал ширмэл синтофон материалыар хийгдсэн.

В. Цэвэрлэгээ, угаах үед хялбар байх

Г. Бүч бүхий малгайтай

Е. Бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалж өргөн хийгдсэн.

Ё. Энгэрийн дунд хэсэгтээ ташуу далд халаастай. Ташаандaa эзлэхүүнтэй ил халаастай жижиг энгэр, ар нуруунд гэрэл ойдог түүз болон саарал өнгийн оруулгатай

5.2.2. Өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна

А. Нуруугаар салхи орохоос хамгаалах, бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөхрезинэн оруулгатай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой өвдгэнд 2 хуниастай байна.

Б. цэвэрлэгээ, угаах үед хялбар болгох
 В. Өвдөгний хэсэгт давхарлагатай
 Г. Арын суудлын хэсэгт давхарлагатай
 Д. Ташааны оёдолд орсон халаастай
 Е. Хоёр хажуу талдаа тагтай эзлэхүүнтэй ил халаастай

5.3. Ажлын тусгай хувцасны загварыг 5-р хүснэгтэд заасаны дагуу байна.

5-р хүснэгт

Ажил мэргэжлийн нэрс	Өвлийн хувцасны загвар	Зуны хувцасны загвар
Ажлын тусгай хувцсаар хангагдах 1А-р хэсэгт орсон ажилтнууд	Өмд+хүрэмний хослол	Өмд+хүрэм+хантааз
Ажлын тусгай хувцсаар хангагдах 1Б-р хэсэгт орсон ажилтнууд		Хантааз
Ажлын тусгай хувцсаар хангагдах 2-р хэсэгт орсон ажилтнууд		Өмд+Халат+Малгай
Ажлын тусгай хувцсаар хангагдах 3-р хэсэгт орсон ажилтнууд	Өмд+хүрэмний хослол	Өмд+хүрэмний хослол
Ажлын тусгай хувцсаар хангагдах 4А-р хэсэгт орсон ажилтнууд	Өмд+хүрэмний хослол	Өмд+Хантааз
Ажлын тусгай хувцсаар хангагдах 4Б-р хэсэгт орсон ажилтнууд	Хүрэм	Хүрэм+Халат

6.1. Ажлын тусгай хувцасны материалд тавигдах шаардлага

6.1.1. Өнгө материалд тавигдах шаардлага

6.1.1.1. Ажлын хувцасны өнгө материал нь эрчтэй утсаар саржа, өсгөмөл саржа, диогналь нэхээсээр нэхсэн нэхмэл даавуу байна.

6.1.1.2. Хувцасны материал нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хүний биед нөлөөлөх химийн бодис, хүчин зүйлгүй. Жишээ нь хөлстэй наалдах үед харшил өгөхгүй.

6.1.1.3. Тос нэвчихгүй. Нефть, тос ус нэвтрүүлэхгүй. Хүчилд тэсвэртэй. Хамгаалах чадварыг сайжруулах зорилгоор байгалийн ба хиймэл ширхэгт, түүний холио болон төрөл бүрийн боловсруулалт (ус үл нэвтрүүлэх, тос үл нэвчих) хийсэн материалуудыг хэрэглэнэ.

6.1.1.4. Цахилгаанжихгүй. Цахилгаан зайлцуулагчтай.

6.1.1.5. Амархан бохирдохгүй. Хэрэглээний дараа хялбар цэвэрлэгддэг байх. Цэвэрлэгээний үед болон нойтон боловсруулалтын үед будаг гарахгүй байх.

6.1.1.6. Галд тэсвэртэй.

6.1.1.7. Хиймэл болон холиотой ширхэгт агуулсан тусгай зориулалтын хувцасны материалын гадаргуугийн цахилгаанжилтийн эсэргүүцэл нь 10 ОМ-оос ихгүй байна.

6.1.1.8. Хувцасны материалын физик-хими, физик механикийн шаардлага, үзүүлэлтүүд нь 6-р хүснэгтэд заасанаас багагүй байна.

Ажлын хувцасны өнгө, материалын физик, хими, физик механикийн үзүүлэлт

6-р хүснэгт

Үзүүлэлт, нэгж	Нэгж	Норм хэмжээ	Турших стандарт
Ширхэгийн бүтээгдхүүн Хөвөн Полиэстер	%	80-аас багагүй 20	MNS 4010-2009
Эвдрэлийн ачаалал Суурь Хөндлөн	H	780-с багагүй 650с багагүй	MNS 1835-6: 2007

Эвдрэл тэсвэрлэх чадвар - Суурь Хөндлөн	H	51-с багагүй 36с багагүй	MNS 1835-6: 2007
Угаалт тэсвэрлэх чадвар - Ноосон даавуу - Хөвөн даавуу - Синтетик холиотой	Цикл	4500-с багагүй 3500с багагүй 5500с багагүй	MNS 1835-7:2007
Агаар нэвтрүүлэлт -агаарын эзэлхүүн -агаарын хэмжээ	л/цаг см ² мм/с	800-с багагүй 300-с багагүй	MNS ISO 9237
Үс нэвтрүүлэх чадвар	мм.м.у.б	200-с багагүй	MNS ISO 1835-7-2007
Нойтон боловсруулалтын дараах шугаман хэмжээний өөрчлөлт - Суурь - Хөндлөн утасны дагуу	%	-3,5с ихгүй +2.0-с ихгүй	MNS 1835-9:2007
Будгийн тогтвортойлалт - угаалт - хөлс - Хуурай үрэлт	балл	4 балл	MNS 4072-88 MNS 4069-88 MNS 4070-88 MNS 4073-88
органик уусгагч буюу хими цэвэрлэгээнд			
Нэхээсний нягт Тууш Хөндлөн	тоогоор	162-оос багагүй 300-с багагүй	MNS 1835-4-2007
Зузаан I.II.IY бүлэг ажилтны хувцас III бүлэг ажилтны хувцас	мм	0.4 –өөс багагүй 0.82 –аас багагүй	MNS 1835-3-2007
Элэгдэл тэсвэрлэлт I.II.IY бүлэг ажилтны хувцас III бүлэг ажилтны хувцас	Эргэлтийн тоо	20000-с багагүй 25000-с багагүй	ISO-12947-2

6.1.2. Өвлийн хувцасны дотрын материал

6.1.2.1. Хувцасны зориулалттай дотрын материал нь хувцсыг өмсөх тайлахад хялбар байна.

6.1.2.2. Дотор нь өмсөж буй хувцастай үрэлт үүсгэхгүй байна.

6.2.3 Дотрын материал нь атлас нэхээстэй гөлгөр даавуу байна.

6.2.4 Дотрын материалын физик-хими, физик механикийн шаардлага, үзүүлэлтүүд нь

7-р хүснэгтэд заасанаас багагүй байна.

Дотрын материалын физик- хими, физик механикийн үзүүлэлт

7-р хүснэгт

Үзүүлэлт	Нэгж	Нормт хэмжээ	Шалгах стандарт
Гадаргуун жин	г/м ²	110-с багагүй	MNS 1835-3:2007

Байгалийн болон вискоз ширхэгийн агууламж Ширхэгийн бүтээгдхүүн Хөвөн Полиэстер	%	80-с багагүй 20	MNS 4010-97 MNS 4010-2009
Эвдрэлийн ачаалал - Суурь - Хөндлөн	Н	216-с багагүй 177-с багагүй	MNS 1835-6:2007
Угаалт тэсвэрлэх чадвар	цикл	1500-с багагүй	MNS 1835-6:2007
Сүвэрхэг байдал	%	10-с багагүй	MNS 1835-5:2007
Нойтон боловсруулалтын үеийн хэмжээний өөрчлөлт - суурь - хөндлөн	%	-3,5-с ихгүй +/-2,0-с ихгүй	MNS 1835-9:2007
Будгийн тогтвортой - угаалт - хөлс - хуурай үрэлт - органик уусгагч буюу хими цэвэрлэгээнд	балл	4балл	MNS 4072-88 MNS 4069-88 MNS 4070-88 MNS 4073-88

6.3 Ажлын хувцасны дулаалгын материал

6.3.1 Материалын төрөл түүнд тавигдах шаардлага

6.3.1.1 Ажлын тусгай хувцас нь өвөл болон зуны улиралд өмсөх хоёр төрөл байна.

6.3.1.2 Зуны улиралд өмсөх ажлын тусгай хувцасны хүрэм зузаан, зөвлөн даавуун дотортой байна. Өвлийн улиралд өмсөх зориулалт бүхий ажлын тусгай хувцас нь дулаалгатай байна.

6.3.1.3 Дулаалга доторлогооны материалыг -30 С-аас – 40 С хүртлэх температурт өмсөж, хэрэглэх нөхцлөөр тооцож сонгоно.

6.3.1.4 Ажлын хувцасны сентифон дотортой давхар зөвлөн даавуун ширээстэй дулаалгатай материалыг хэрэглэнэ.

6.3.1.5 Ажлын байр, ажил мэргэжил бурд харгалзах өвлийн хувцасны дулаалгын материалын төрөл, зузааныг 8 дугаар хүснэгтэд үзүүлсэний дагуу өвлийн хувцсанд хэрэглэнэ.

Өвлийн улиралд өмсөх хувцасны дулаалгын материалын төрөл, зузаан

8-р хүснэгт

№	Ажлын хувцасны ангилал	Зуны хувцас, дотор				
		Өмд	Хүрэм	Өмд	Хүрэм	Хантааз
1	Ажлын хувцас олгох I А хэсэг	Синтопон, давууны хамт ширмэл	Синтопон, давууны хамт ширмэл		Зузаан зөвлөн даавуу	
2	Ажлын хувцас олгох II Б хэсэг					
3	Ажлын хувцас олгох III хэсэг	Синтопон, давууны хамт ширмэл	Синтопон, давууны хамт ширмэл			
4	Ажлын хувцас олгох IV хэсэг		Синтопон, давууны хамт		Зузаан зөвлөн даавуу	

		ширмэл				
--	--	--------	--	--	--	--

7. Ажлын хувцасны хэмжээ

- 7.1 Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.
- 7.2 Ажлын хувцасны хяналтын хэмжээг хүний өндөр, цээж болон бэлхүүсний тойргийн уртаар тодорхойлно.
- 7.3 Хувцасны хэмжээг тогтооходоо хүн тус бүрээс 2 удаа хяналтын хэмжээг авч гүйцэтгэнэ.
- 7.4 Хувцасны суултыг хангах хэмжээг пиктограммаар үзүүлэх ба хүний биеийн өндөр, цээжний бүслүүр, бүсэлхийн тойрог, өгзөгийн тойргийн хэмжээг тавьсан байна.
- 7.5 Өндөр, цээжний болон бэлхүүсний тойргын уртын хэмжээ 9-р хүснэгтэд заасантай тохирч байна.
- 7.6 Ажлын хувцасны хэмжээг тэмдэглэх жишээг дараах байдлаар үзүүлэв. Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.

Хувцасны хэмжээний хүснэгт

9 дүгээр хүснэгт

Биеийн өндөр (рост)	Биеийн өндрийн хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см	Цээжний тойргийн хэмжээ (размер)	Цээжний хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см
146,152	146....155	88, 92	86 ... 94
158,164	155....167	96, 100	94.... 102
170, 176	167....179	104, 108	102...110
182, 188	179....191	112, 116 120, 124 128, 132	110....118 118... 126 126....134

Эрэгтэй хүний биеийн хэмжээг авахдаа :

Өндөр
Цээжний тойрог
Бэлхүүс
Гарын урт

Хөлний урт зэрэг хяналтын хэмжээг 3 дахин авна.

Эмэгтэй хүний хэмжээг авахдаа :

Өндөр
Цээжний тойрог
Бэлхүүс Таазны
хэмжээ Гарын
урт

Хөлний урт зэрэг хяналтын хэмжээг 3 дахин авна.

Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

10 дугаар хүснэгт

Эрчүүдийн хэвийн хэмжээ	40 42 44 46 48 50 52 54	Том 56 58 60 62 64
Цээжний	80 84 88 92 96 100 104 108	112 116 120 124 128
Өндрийн	158 164 168 171 177 180 182	184 186 186 187 187
Бэлхүүсний	68 72 76 80 84 88 92 98	102 108 112 118 122
Гарын урт	56 57 58 59 60 61 62 63	64 65 66 67 68
Хөлний урт	71 73 74 76 78 79 80 81	82 83 83 83 83

Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

Эмэгтэйн хэвийн хэмжээ	36 38 40 42 44 46 48	Том 50 52 54
Цээжний	84 88 92 96 100 104 110	116 122 128
Өндрийн	168 168 168 168 168 168 168	168 168 168
Бэлхүүсний	66 70 74 78 82 86 92	98 104 110
Таазны	91 94 98 102 105 109 114	120 125 131
Бэлхүүсээс хөлний ул хүртэл хэмжээ	106 106 106 106 106 106 106	106 106 106

Туранхай эрэгтэй хэмжээ	Том биетэй хүний хэмжээ	Намхан хүний хэмжээ	Бэлхүүсний хэмжээ		
Цээжний K 90 94 98 102	106 110 114	24 25 26 27	28	51	53 55 57 61
Цээжний K 98 92 96 100	104 108 122	96 100 104 108	112	100	104 108 112 120
Өндрийн K 177 180 183 186	188 190 192	168 171 174 176	178	170	172 174 176 179
Бэлхүүсний K 76 80 84 88	92 96 100	88 92 96 100	106	108	112 114 116 130
Гарын урт F 62 63 64 65	66 67 68	59 60 61 62	62	61	62 63 64 66
Хөлний урт F 80 81 82 83	84 85 86	73 74 75 76	77	74	75 6 77 79

8. Ашиглалтын хугацаа

8.1 Ашиглалтын хугацааг дараах хүчин зүйлээс хамааруулан үзнэ. Үүнд: цэвэрлэгээ, өнгө гандалт, хэмжээний өөрчлөлт зэрэг болно.

8.2 Ажлын хувцасны эдэлгээний, ашиглалтын хугацааг Зам, тээврийн хөгжлийн төвийн Захирлын тушаалаар батлуулж мөрдөнө.

8.3 Ажлын тусгай хувцас нийлүүлэгч аж ахуй нэгж, үйлдвэрлэгч нь ашиглалт эдэлгээний явцад хувцасны чанар, үр ашигт орох өөрчлөлт нь заасан хугацаанд энэ стандартын шаардлагад нийцсэн хувцсыг нийлүүлнэ. Ашиглалтын дурьдагдсан хугацаанд хувцасны чанарыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.

8.4 Ажлын хувцасны ашиглалт, эдэлгээний хугацаанд худалдан авсан үнэ, чанар хийц болон байгаль цаг уур, гэнэтийн хүндрэлтэй нөхцлөөс шалтгаалан нэмэлт өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлтийг тухайн үеийн үүссэн нөхцөл байдлыг дүгнэн компанийн техникийн комисс тогтооно. Жишээ нь: Хурдны замын алба, лабораторийн туслахад гэнэтийн болзошгүй хүчин зүйлийн улмаас цаашид ашиглах бололцоогүй болсон үед ашиглалтын хугацаанаас өмнө устгаж шинээр хувцас олгоно.

8.1. Цэвэрлэгээ

8.1.1. Угаалга

8.1.1.1. Ажлын тусгай болон энгийн хувцсыг ангийн ба химийн аргаар цэвэрлэх боломжтой байна.

8.1.1.2. Ус үл нэвтрүүлэх, ус-тос үл нэврүүлэх, үл цахилгаанжих нэмэлт хамгаалах чадварын үзүүлэлтүүд нь 5 удаагийн угаалтын дараа анхны шинж чанараа хадгалж байх ёстой.

8.1.2. Цэвэрлэгээний дараах хэмжээний өөрчлөлт

Химийн болон энгийн цэвэрлэгээний дараа ажлын хувцасны материалын хэмжээний өөрчлөлт

урт ба өргөнөөрөө 3 хувиас хэтрэхгүй байна.

8.2. Тэмдэглэгээ

- 8.2.1. Байгууллагын нэр
- 8.2.1.1. Ажлын тусгай хувцас бүрийн зүүн дээд энгэрт байгууллагын нэр, логог тэмдэглэсэн тэмдэглэгээтэй байна.
- 8.2.2.2. Ажлын тусгай хувцасны арын дээд талд алба нэгжийн нэрийн хатгамлыг биеийн цээж хэсгийг голлуулан байрлуулна.
- 8.2.2.3 Тэмдэглэгээ нь нүдэнд харагдахуйц тод бөгөөд ойлгомжтой байх
- 8.2.2.3. Цэвэрлэгээний үйл явцад арилахааргүй байх
- 8.2.2.4 Тэмдэглэгээ нь боломжийн хэмжээний том, тод ойлгомжтой шифрээр бичсэн байна.
- 8.2.2.5. Нэрийн үсгүүдийг хатгамалын машинаар хатгаж оёно
- 8.2.2.6 Хүрэмний зүүн энгэрт байрлах байгууллагын нэр бүхий хатгамлыг тагтай халаасны дээр түүнээс 5 мм зйтай оёно

8.2.3 Бүтээгдэхүүний тэмдэглэгээ

Ажлын тусгай хувцасны үйлдвэрлэгч нь өөрсдийн бүтээгдэхүүний талаар дараах мэдээллийг агуулсан тэмдэглэгээ, шошготой байна.

- А. Бүтээгдэхүүний төрөл болон нэр
- Б. Хэмжээ, размерын тэмдэглэгээ
- В. Тухайлсан стандартын дугаар
- Г. Ашиглалтын заавар
- Д. Хувцсыг хийсэн материалын гал тэсвэрлэх чадварыг тодорхой заасан байх
- Е. Хэрэглээний хязгаарлалт (температурын горим г. м.)
- Ё. Ашиглалтын үеийн арчилгааны зааврыг тусгасан байна. Угаах, индуудэх заавар

Г.М.

...ооо...